

**МОНГОЛ БИЧИГ БУЙ БОЛСОН ЦАГ ХУГАЦААНЫ ТАЛААР
ЭРГЭЦҮҮЛЭХ УЧИР ХОЛБОГДОЛ**

Ц.Шагдарсүрэн¹

Энэхүү өгүүлэлийг бичигч монгол бичигийн гарал үүсэл, цаг хугацааны талаар анхаарч үсэгзүй болон монгол бичигийн хэлний онцлогийн талаас нь судлаж гэмээ нь судлагчидын дунд маргаантай дээрхи асуудалыг ац хагалан шийдэхэд нэгэн шат болохын дээр холбогдох шинэ сэргэ баримт хэрэглэгдэхүүнийг нэмж толилуулах шаардалгатай хэмээн бодсоор ирсэн бөгөөд анх энэ сэдэвээр 1976 онд нэгэн өгүүлэлдээ, дараа нь 1977 онд болсон Олон улсын Монголч эрдэмтэний III их хуралд нэгэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн билээ². Тэрхүү илтгэлдээ тухайн үед эрдэмтэдийн дунд төдий л анхаарал тавьж амжаадүй төвөд сурвалж, түүний дотороос Заваа Дамдин авгайн “Хорчойнжунг” буюу монгол бүтэн нэрээрээ “Умар зүгийн Монгол оронаа дээд ном эрдэнэ гарсан ёсоны домог өлзийт цагаан лавай мүшээсэн дуун эгшиг орошибай”³ хэмээх бүтээлийн төвөд монгол хэлээрхи заваад буй холбогдох мэдээ сэлтийг судлагааны эргэлтэд оруулан толилуулахыг хичээсэн бөлгөө. Үүнээс хойш ч уг сэдэвийг хойш тавилгүй, хэрэглэгдэхүүний олдоцоос хамааран их бага аль нэгэн хэмжээгээр нэмэн үргэлжлүүлсээр ирсэн билээ⁴.

Одоо эргэн үзвэл, тухайн үед судлагааны ажилын туршилга нимгэнээс үүдэн гол хэрэглэгдэхүүнээ анхаараад, холбогдох бусад баримт сэлтийг хангалттай дурдаагүй зэрэг дутуу дулим ажигласан байдал эрхгүй харагдах тул тэрхүү алдаагаа эргэж засах, орхисон баримтыг тэнхэрүүлэн харгалзах хэрэгтэй хэмээн бодож энэхүү өгүүлэлийг бичив. Ийнхүү бичихэд профессор Ш. Чоймаагийн нийтлүүлсэн түрүүчийн орчуулгуудыг төвөд эхтэй нь тулган зассан монгол орчуулгын өөр нэгэн хувилбар⁵, мөн

¹ ШУ-ы доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Ц. Шагдарсүрэн, “Монголчуудын үсэг бичгийн эвхмэл хэлбэр”, - *Studia Mongolica*, Tom. IV (12), Fasc. 15, Ulaanbaatar, 1976, (339-360) 357-358-талын 6-р зүүлт; Ц. Шагдарсүрэн, *К вопросу о происхождении монгольского письма*, - Олон улсын монголч эрдэмтний III их хурал, III боть, Улаанбаатар, 1978, 286 - 290 х.

³ *Byun phyogs hor gyi yul du dam pa'i choi rin pu che 'byur tshul gyi gтам rgyud bkra sis chos dun bzad pa'i sgra dbyuns zes bya ba bzugs so - Umar-a jüg-ün mongjol oron-a dededü nom erdeni жаруушан yosun-u domuу öljei-tü labai müsiyegsen da run egesig orosibai*, 10b-12b.

⁴ Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэгзүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, 11-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 24-25-р тал.

⁵ Ш. Чоймаа, *Зава Дамдины “Хорчойнжунг”-гийн монгол орчуулга хийгээд зарим тэмдэглэл*, - Лавайн эгшиг (Гандан Тэгчинлин хийд), Улаанбаатар, 1997, 39-55; Ш. Чоймаа, *Зава Дамдины “Хорчойнжунг”-гийн монгол орчуулга хийгээд зарим тэмдэглэл*, - Ш. Чоймаа, *Монголын судлалын өгүүлэлүүд*, Улаанбаатар, 2003, 306 -324-р тал.

Заваа Дамдин ламтаны эснэсэний 140 жилийн ойгоор тойн Лувсандаржаагийн шинэчилсэн орчуулгаар гарсан “Хор чойнжунг зава”⁶ хэмээх ном (2007) багагүй түлхэц болсоныг хэлэлгүй орхих аргагүй.

Уг номын гутгаар буюу Лувсандаржаагийн орчуулгаар нэгэн холбогдох хэсэгийг эшлэн толилуулая.

“...Тэгүүн (шашин ном Ц. Ш.)-лүгээ барилдан Монгол нутгийн төв, өвөр-лүгээ ч бас Тэнцэш үгүй дээдийн ном түгэн дэлгэрсэн нь үзэгдэх бөгөөд Тэр нь бас Сэлэнгэ мөрний хойд эрэг дэх “Баян балгад” хэмээх Монгол балгад дор Тэртээх Ил Тарвагатайн чанадын зүгээс “Согтаг” нэрт Монголын нэгэн аймаг Арилжаа худалаа хийхээр ирж нутагшин суусны Арвис мэргэн багш нар-бээр Уйгур хийгээд Монголчууд-дор Аливаа үсэг хийгээд унших бичих тэргүүтэй Аугаа бурханы номлолын зарлиг, шастир сайн айлдал-нугуудыг Аливаа өөр өөрийн хэл-лүгээ орчуулахуйн ёсыг заан сургав...”⁷

Миний түрүү түрүүчийн өгүүлэл, номд дээрхи есөн шадын сүүлчийн дөрвөн мөр нь хуучин хадмал орчуулгаар багтсан бөгөөд⁸, харин эхиний таван мөр нь уг төвөд эх болон монгол орчуулгаараа ороогүй билээ. Түрүүн ороогүй тэрхүү мэдээ нь монгол бичиг үүссэн цаг хугацаанд шууд хамаарах тодорхой баримт гэдэгийг энд онцлон дурадвал зохино. Хэдийгээр Заваа ламтаны бүтээлд Согдыг монгол аймаг хэмээсэн нь эргэлзээтэй⁹ боловч согдууд Баян балгадад худалдаа арилжаа эрхилэж байсан, монгол нутагаас согд бичээстэй хэд хэдэн дурасхал олдсон¹⁰, согдуудын уугуул нутагт байдаггүй монгол тэмээний дүрс бүхий согд зоос байдаг¹¹ зэрэг Согд хийгээд Монгол угсаатаны хооронд эдийн засаг, соёлын харилцаа холбоотой байсаныг батлах олон баримт хэдийнээ тодорхой болжээ. Согд нарын талаархи мэдээ анх персийн “их хаан”, “хаадын хаан” хэмээгдэгч Дарий хааны тухай шаантаг бичигт *Suguda / Sugda* гэдэг хэлбэрээр гардаг бөгөөд “түүхийн эцэг” гэдэг нэрийг олсон Герегийн Херодот (Herodote)-ын бүтээлд Σοῦδο хэмээн тэмдэглэгджээ. Бас Македоны Александрын

⁶ Заваа Дамдин, *Хор чойнжунг зава* (Умард зүгийн монгол оронаа дээдийн ном эрдэнэ үүдэн гарсаны түүх цадиг өлзий хутагийн мүшээх Лавайн эгшиг дуун хэмээх оршивай), Төвөдөөс орчуулсан тойн Лувсандаржаа, Улаанбаатар, 2007, 87 тал.

⁷ Заваа Дамдин, *Хор чойнжунг зава* (Умард зүгийн монгол оронаа дээдийн ном эрдэнэ үүдэн гарсаны түүх цадиг өлзий хутагийн мүшээх Лавайн эгшиг дуун хэмээх оршивай), Төвөдөөс орчуулсан тойн Лувсандаржаа, Улаанбаатар, 2007, (87 тал) 29-р тал.

⁸ "...pksi-mkhas-pa-rnam-kyis-yu-gur-dan // mon-kol-rnam-la-yi-ge-'bri-klog-dan // ston-pa'i-idam-chos-bka'-bstan-gsun-rab-rnam // ran-ran-skad-du-bsgyur-tshul-ston-cin-bslabs // ..." буюу монголчлосон нь: "... (Согдын Ц.Ш.) mergen baysi-nar-bar uuyur kiged mongyol-nuyud-tur üsüg bičikü ungsiqu ba : burqan-u degedü nom jarliy sastar-a sayin jarliy-ud-i öber über-ün kele-ber orčiyulqu yusun-i üjegüljü suryabai..."

⁹ (Төвөд бичвэрт *согдаг* ~ *согтаг* хэмээн гарч буй) Согд нарын гарал угсаа хийгээд тэдний үүх түүхийн талаар өрнө дахины эрдэмтэдийн судлагааг ашиглан бичсэн дараахи өгүүлэлээс тодруулан үзэх ажаамуу. Ф. Розенберг, *О согдийцах* – Записки коллегии востоковедов при Азиатском музее Российской Академии Наук, Том. 1, Ленинград, 1925, стр. 81-90.

¹⁰ S. G. Klyastornyj, V. A. Livsic, *Une inscription inédite turque et sogdienne: La stèle de Sevrey (Gobi meridional)*, JA, 1971, Paris, pp. 11-20; S. G. Klyastornyj, V. A. Livsic, *The Sogdian inscription of Bugut revised*, - АОН, Том. XXVI, Fasc. 1, Budapest, 1972, pp. 69-102.

¹¹ О. И. Смирнова *Сводный каталог согдийских монет* (бронза), Москва, 1981; О. И. Смирнова *Двугорбый верблюд на согдийских монетах*, Страны и народы Востока, вып. XXV, Москва, 1987, стр. 142-148; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Улаанбаатар, 2001, 27-28-р тал.

түүхчид Согд нарыг үлэмжихэн анхаарч байсан төдийгүй, Александр Согдыг дайлаад соёл нь өндөр, феодалын төр улс нь боловсронгуй, суртал ёс нь гүн, эрх чөлөөг эрхимлэдэг улс болохыг нь арга буюу хүлээн зөвшөөрөхөд хүрсэн гэдэг¹².

Харин Заваа Дамдины бүтээлд Сэлэнгийн Баян балгад буюу одоо бидний Байбулаг (< бай балык) гэдэг газар согдууд худалдаа арилжаа эрхилэхийн сац уйгур хийгээд монголчуудад бичиг үсэг, шашин номын суртал заасан тухай барим тавим тодорхой баримт байгаа нь үлэмжхэн сонирхол татахын хажуугаар хэлшинжлэлийн үүднээс монгол бичигийн хэлний байдал нь Баян балгадыг цогцлоосон тэр үеийн буюу VII-VIII зууны монгол хэлний онцлогийг тусхасан гэж үзэх үндэслэл болж өгнө.

Монгол, уйгур бичигийн хэлэнд бурхан шашины самгард нэр томъёо адил мэт холилдон байдаг тухайд: “Хор чойнжунг”-д буй монгол бичигийн түүхэнд шууд холбогдох өөр нэгэн хэсэгийг нэмэн эшлэе.

“...Аяа тэр цаг-дор Уйгур Монголын аймаг-нугууд

Аврал гурван эрдэнэ-дор итгэл одуулан тахиж

Алимад сүм дуган бүтээн, лагшин, зарлиг, таалалын шүтээн босгож

Ариун шагшаабадийг сахисан номын хүрээ олноор байгуулав.

Тэр цагт тэд-бээр номлол сургаалийг уншихуй-дор

Тэгш босоо Согтаг үсгээр Энэтхэг хийгээд өөр өөрсдийн хэлийг хольж орчуулан

Тийн номлол, сонсгол, уншлага тэргүүтэнийг үйлдсэн нь үзэгдэнэ.

Тэрхүү шалтгаанаар эдүгээ ч бас нүүдэлчин монголын номын хэллэг-ину

Тэртээх Энэтхэг, Уйгур, Монголын хэл холилдон оршмуй.

Тийм бөгөөс Монголын үсэг бичгийг

Тэнцэжгүй Сажа Бандида-бээр зохиов хэмээсэн-ину

Тэнсэл үгүйгээ эндүүрэлт яриа мөн болой.

Аливаа бас Монголын энэхүү төв нутаг-дор Согтаг нугууд

Алс Энэтхэг орноос Бүддийн шашины ёс хийгээд

Алимад наран ургах зүгээс Манихейн шашины ёс хоёрыг

Авч залан ирсэний дараагийн ул мөр болбоос

Аливаа Монголчуудын галын тахилга ба уулын тахилга хэмээх гарчээ...”¹³

Дээрхи эшлэлтэй дүйх хэсэгийг миний бие төвөд монгол хадмал орчуулгаас эшлэн авч номдоо удаа дараа оруулсаныгаа толилуулбал доорхи мэт болно:

“...Тэр цагт тэд (Уйгур болон Монголчууд Ц. Ш.) сайн зарлигийг уншихуйд согдаг бичгийн дээрээс энэдхэг хийгээд өөр өөрийн хэлнүүд холимоогоор орчуулсанаас, номлон соносох амны уншилгыг үйлдсээр буй ажгуу. Тэр шалтгаанаар одоо манагаар ч номын хэл нь энэдхэг, уйгур, монгол холимоогоор оршисон болой. Тиймийн тул монгол үсэг үүнийг Сажа Бандида-баар урлав хэмээх итгэмээргүй үг буй. Бус бас Монгол орны дунд Согдаг-нугууд Энэдхэгийн ороноос Бүддын ном ёсон хийгээд наран шингэхүй зүгээс Маанийн ном ёсон хоёрыг залж ирсэн...”¹⁴

¹² Ф. Розенберг, *О согдийцах*, - Записки коллеги Востоковедов при Азиатском музее Российской Академии Наук, Том. 1, Ленинград, 1925, стр. 81 – 90.

¹³ Заваа Дамдин, *Хор чойнжунг зава (Умард зүгийн монгол оронаа дээдийн ном эрдэнэ үүдэн гарсаны түүх цадиг өлзий хутагийн мүшээх Лавайн эгшиг дуун хэмээх оршивай)*, Төвөдөөс орчуулсан тойн Лувсандаржаа, Улаанбаатар, 2007, (87 тал) 30-31-р тал.

¹⁴ Ц. Шагдарсүрэн, *К вопросу о происхождении монгольского письма*, - Олон улсын монголч эрдэмтний III их хурал, III боть, Улаанбаатар, 1978, 286 - 290 х.; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэгзүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, 10-11-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 24-р тал.

Нэг бус судлалч XIII зуунд монголчууд монгол бичигээ уйгураас авсаны батлагаа нь бурханы шашины олон самгард нэр томъёоны бичилгэ нь монгол болон уйгуруур адилхан байдаг хэмээн батлахыг оролддог билээ. Гэвч нарийвчилан үзвэл бичилгэ тохирох явдал буй боловч бас үл тохирох олон баримт байдаг тухай энэ өгүүлэлийн зохиогч тэмдэглэсээр ирсэнээс гадна академич Б. Я. Владимирцов тэдгээр нэр томъёо согдтой холбоотойг тодорхой батлан бичсэн билээ¹⁵. Дээрхи эшлэлээс үзвэл Заваа Дамдины авгай “Хор чойнжунг”-доо яагаад самгард, монгол, уйгур хэлэнд бурханы шашины нэр томъёо тийнхүү холимог байдаг талаар нэлээд тодорхой тайлбарлажээ.

Тэгвэл энэ үеийн буюу монгол хэлний хөгжилийн үечилэлээр эртний монгол хэлний харьцангуй сүүл үед хамаарах монгол хэлний байдалыг монгол хэлний холбогдох бусад баримттай харьцуулна гэвэл цаг хугацааны дараалалаар түрүү үед хамаарах нь бидний одоогийн мэдэх хэмжээгээр академич Л. Лигети (L. Ligeti)-йн судласан Табгач буюу Сянби нарын хэлний хэрэглэгдэхүүн¹⁶, дараа үед хамаарах нь хятан хэлний баримт болж байна. Өөрөөр хэлбэл, монгол бичигийн хэл нь цаг хугацааны хувьд Сянби болон Хятан нарын хэлний хооронд хамаарна гэсэн хэрэг бөгөөд хэлзүйн хувьд чухам алинд нь илүү ойр болохыг тодорхойлох нь монгол бичигийн үүсэлд шууд хамаарна гэсэн үг.

Баян балгад болон түүний тухай баримт мэдээ агуулсан Моюн чүрийн бичээсийн тухай: хэлний онцлогийг өгүүлэхийн өмнө “Хор чойнжунг”-д гарч буй *Баян балгад* буюу одоо туурий нь нутагийн олон нийт Бай булаг хэмээсээр буй хотын талаар тодруулах нь зүйтэй гэж санана. Энэхүү хотын талаархи хамагийн эртний баримт гэвэл рүн бичигээр уламжлаж ирсэн Моюн-чүрийн гэрэлт хөшөөний бичээст (Г. Айдаровын орос орчуулгаар эшлэвэл) “...*После этого Согдам и Табгачам я дал [приказ] на [берегу] Селенги построит [город] Бай-балык...*” - “Сэлэнгийн эрэгт Бай-балык буюу Баян балагасун хэмээх хот цогцолуулахыг согд, табгач нарт зарлиг болгов, би” хэмээн гардаг бөлгөө¹⁷. Энэ бичээс нь хэдийгээр (түрэгийн) рүн бичигээр байгаа боловч Уйгурын хаант улсад хамаарах анхны дурасхалуудын нэг бөгөөд агуулгын хувьд Моюн-чүрийн аян дайныг түүхчилэн тэмдэглэжээ. Уг дурасхалыг анх Рамстедт (G. J. Ramstedt), дараа нь Ван Цзин-жү, С. Е. Малов нар орчуулж В. Томсен (V. Thomsen), А. Н. Бернштам нар судлагаандаа хамруулсан байдаг.

Моюн-чүр бол 745 онд Түрэгийн сүүлчийн хаан Озмыш-тегинийг дийлсэн Уйгурын хаан. Тийм ч учираас энэ бичээсийг уйгуруудынхи гэж үздэг. Тэгээд ч судлагчид Уйгурууд яагаад уйгур бичигээрээ биш, рүн бичигээр бичсэн бэ? гэж сонирхин тэмдэглэсээр иржээ¹⁸.

Анхдугаар мянганы сүүлчээр буй болсон гэдэг уйгур бичигээрээ энэ дурасхалыг яагаад бичэлгүй түрэгүүдийн хэрэглэж байсан рүн бичигээр бичив ээ? гэдэг нь олон зүйлийг эргэцүүлэн бодох шаардалгатайг харуулж байна. Тийнхүү рүн бичигээр уг

¹⁵ Б. Я. Владимирцов, *Mongolica* Об отношении монгольского языка к Индо-европеским языкам Средней Азии. - Записки Коллеги Востоковедов, N. 1, Ленинград, 1925, стр. 305-341.

¹⁶ L. Ligeti, *Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi*, - *Mongolian Studies*, edited by L. Ligeti, Budapest, 1970, p. 265-308.

¹⁷ Г. Айдаров, *Язык орхонских памятников древнетюркской письменности VIII века*, Алма-Ата, 1971, стр. 352 (Памятник Моюн-Чору: Западная сторона, 44).

¹⁸ Г. Айдаров, *Язык орхонских памятников древнетюркской письменности VIII века*, Алма-Ата, 1971, стр. 32.

түүхэн дурасхалыг бичсэн нь тухайн үед тухайн газар нутагт үлэмжхэн хэрэглэгдэж байсан рүн бичигийн эрчийг харгалзан үргэлжлүүлсэний дээр тэрхүү бичиг угаасаа Хүннү-гийн үеэс Цагаан хэрэмийн ар биеэр нутаглаж асан нум сум агсагчид – нүүдэлчидийн дунд (үүнд өвөг монголчууд ч бүрэн хамаарна¹⁹) нийтлэг нөлөөтэй байсантай холбоотой байж болох нэгэн үндэс буй. Үүний дээр Монгол Уйгур хоёр Согдын мэргэн багш нараар ном бичиг заалгаж, орчуулах эрдэмд сурсан гэх Заваа Дамдины “Хор чойнжунг” дахи мэдээг бодолцох бөгөөс тулгар буй болсон уйгур бичигийн хэл тэр үед хангалттай боловсорч амжаагүй, Моюн-чүрийн аян дайны бүхий л үйл явдалыг тийнхүү түүхчилэн дэлгэрэнгүй тэмдэглэхэд хүчирдэлтэй байсан ч байж болохыг үгүйсхэх аргагүй.

Монгол угсааны Сянби нарын хэлний дараа үе, Хятан нарын хэлний түрүү үед хамаарах монгол бичигийн хэлний онцлогийн тухайд: Монгол бичигийн хэлний онцлогийг харьцангуй түрүү болон дараахи үеийн монгол хэлний буюу дээр дурадсан хоёр үеийн дурасхалтай харьцуулж хэлний хувьд алинд нь илүү ойр болохыг тодруулах нь монгол бичигийн хэрэглэж эхлэсэн цаг хугацааг товлох гол баримжаа болж өгдөг.

Тэгээд ч энэ өгүүлэлийн зохиогч уг асуудалд үүнээс өмнө анхаарч сянбийн табгач хэлний судлагааны үр дүн нь монгол бичигийн хэлэнд илүү ойр болохыг авиазүйн хүрээнд тодорхой үгээр жишээ авч товч дурадсан билээ²⁰. Тэр бүхэнийг дахин нуршилгүй, энэ удаад монгол хэлний түүхэн хөгжилийн асуудалыг нангиадын судлалтай холбон үзэх хүсэл эрмэлзэл бүхий залуу судлагч гарч ирэх бөгөөс тэдэнд хэрэг болуужин хэмээн хятад үсэгээр тэмдэглэгдэж бидний үед хүрэлцэн ирсэн сянбийн табгач хэлний хэрэглэгдэхүүнийг хэрхин судласан аргагүйн асуудалыг академич Л. Лигетийн судлагаанд үндэслэж арай дэлгэрүүлэхийг хичээлээ.

Табгач зэрэг ханзаар тэмдэглэсэн эртний монгол хэлний хэрэглэгдэхүүнийг судлах аргазүйн тухайд: XIX зууны сүүл XX зууны эхээр Европ дахины нангиадач эрдэмтэд бараг цөмөөрөө эртний хятад үсэгээр харь үгийг дуудалгаар нь галиглан тэмдэглэж ирсэн баримтад үлэмжихэн анхаарч, хятад хэлний дотоод боломжид байдаггүй, монгол хэлээр жишээлэхэд, одоогийн хятад хэлнээ гурван дэвсгэр гийгүүлэгч байдаг, бүр дээр үедээ үүнээс арай олон байсан гэж үздэг боловч, наад зах нь монгол хэлний есөөс арван нэг гэж үздэг бүх дэвсгэр гийгүүлэгч тус бүрийг хятад хэлний дотоод боломжоор тэмдэглэхэд хүрэлцэхгүй тул тэдгээрийг харь үг хэмээн тусхай дүрэмээр зохицуулан тэмдэглэж байсан гэх мартагдсан тогтолцоог нээн гаргахад түлхүү анхаарсан байдал харагддаг бөгөөд энэ талаархи судлагаа францын *T'oung pao* хэмээх эрдэм шинжилгээний сэтгүүлд онцгой байр эзлэсээр ирсэн нь тодорхой харагддаг билээ. Тухайлбал: энэхүү сэтгүүлд тухайн үедээ нэрд гарсан, одоо ч судлагааны ач холбогдол нь хэвээрээ байгаа Ed. Chavannes, Paul Pelliot, Bernhard Karlgren, Peter A. Woodberg ... зэрэг олон эрдэмтэний судлагааны үр дүн цуврал болж гарсан нь буй²¹. Дээрхи нэр дурадсан эрдэмтэдийн судлагаа нь цөм монголтой

¹⁹ Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 11-21-р тал.

²⁰ Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэгзүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, 10-11-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 23-24-р тал.

²¹ S.H. Schaank, *Ancient Chinese Phonetics*, Part I and II - *T'oung pao*, - Serie I, VIII Vol., Leide, pp. 361-377, 457-486; G. Schlegel, *The secret of the chinese method of transcribing foreign sounds - T'oung pao*, - Serie II, Vol. I, Leide, 1900, pp. 1-, 93-, 219-; Ed. Chavannes, *Inscriptions et pièces de Chancellerie chinoises de l'époque mongole*, - *T'oung pao*, - Serie II, Vol. VI, Leide, 1904, pp. 357-

холбоотой байгааг ч олж харж болно. Үүнээс гадна Henri Maspero зэрэг эрдэмтэд өөр сэтгүүлд нэг бус бүтээлээ хэвлүүлсэн нь одоо ч гэсэн уг судлагдахууны хувьд үнэт хэрэглэгдэхүүн, гарын авалга болсоор байна²².

Тэгээд ч академич Л. Лигети профессор дээрхи эрдэмтэдийн судлагаанд тулгуурлаж Сянбийн Табгач хэлний хэрэглэгдэхүүнийг судлаад монгол хэл болохыг нь тогтоохдоо монгол бичигийн хэлтэй харьцуулан үзсэн байдаг билээ²³. Нэгэн жишээ гэхэд: академич Л. Лигети авгай ханзаар тэмдэглэсэн табгач хэлний зарим баримтыг *ho-k'eou* (энэ нь франц галигаар байгаа бөгөөд оросоор хэкоу гэж галиглаад *правило "закрытого рта"* гэж орчуулдаг²⁴, францаар *la règle de la bouche fermée*) хэмээх дүрэмээр тэнхэрүүлсэн байхаас гадна түрүү үеийн Henri Maspero зэрэг профессорын $t > \delta > r$ (l) гэдэг томъёог анхааран хэрэглэсэн байдаг юм²⁵. Энэ мэтээр *Chinese "mouille" sounds* гэх мэтийн авиазүйн дүрэм журам, шүлэгийн тогтолцоонд шүтэж мөн чанарыг нь тодруулах боломжтой Rhythme зэрэг олон ойлголт үүнд хамаардаг.

Европын эрдэмтэдийн судлагааг үзэхэд харь үгийг тэмдэглэсэн хятад галигийн тухайн үеийн дуудалгыг, жишээлбэл: *m, b, p*-гийн өмнө орсон *n*-ийг *m*-ээр дуудна гэх зэргээр тохиолдол тохиолдолоор нь²⁶, мөн *Тангийн өмнөхи үе...* гэх мэтээр хэлний хөгжилийн үе үеэр нь өртөөчилөн сэргээх зарчмыг баримтласан нь тодорхой харагдана.

Хан улс (х. т. ө. 206 - х. т. 220)-ын үеэс эхлэн хүннүгээс авахуулаад ухуани, сянби, хятан нарыг хүртэлхи, одоогоор өөр баримт авсаар олдохгүй байгаа Монгол үгийг ханзаар тэмдэглэсэн хэрэглэгдэхүүн нь монгол хэлний түүхэнд төдийгүй хятадын судлалд ч үлэмж чухал тул П. Пеллио, Л. Лигети зэрэг европын олон алдарт нангиад судлагчийг монголын судлалд татан оруулсан гэдэгийг тэмдэглэвэл зохино.

Дээрхи асуудалаар нэмэн өгүүлэх нэгэн зүйл: Өмнө өгүүлсэнчилэн хятадаар тэмдэглэсэн харь (монгол) үгийн дуудалгыг өртөөчилөн сэргээх аргын хажуугаар илүү хялбар тодорхойлох өөр нэгэн боломж байж болох талаар үүнээс өмнө толилуулж

447; II partie, - *T'oung pao, é* - Serie II, Vol. VI, Leide, 1905, pp. 1-42; Ed. Chavannes, *Inscriptions et pièces de Chancellerie chinoises de l'époque mongole, (Second série)* - *T'oung pao*, - Serie II, Vol. IX, Leide, 1908, pp. 297-428; Paul Pelliot, *Quelques transcriptions chinoises de noms tibetains*, - *T'oung pao*, - Serie II, Vol. XVI, Leide, 1915, pp. 1-26; Bernhard Karlgren: *Prononciation ancienne de caractères Chinoise figurant dans les transcriptions Bouddhiques*, - *T'oung pao*, 1920; Bernhard Karlgren, *The reconstruction of Ancient Chinese*, - *T'oung pao*, - Serie II, Vol. XXI, Leide, 1922, pp. 1-42; P. Jos Mullie, *Une caractéristique phonologique du dialecte chinois de la Mongolie centrale*, - *T'oung pao*, - Vol. XXIII, Leide, 1924, p. 67 - 82; P. Pelliot, *Sur quelques travaux chinois manuscrits concernant l'époque mongole*, - *T'oung pao*, - Vol. XXVIII, Leide, 1932, p. 378-380; Peter A. Boodberg, *Some proleptical remarks on the Evolution of Archaic Chinese*, - *HJAS* Vol. 2, Cambridge 1937, pp. 329-372;

²² Henri Maspero, *Etudes sur la phonétique historique de la langue Annamite*, Bulletin de l'Ecoles Françaises d'Extrême-Orient (=BEFEO), 1912; Henri Maspero, *Le dialecte de Tch'ang-ngan sous les Tang*, BEFEO, 1920.

²³ L.Ligeti, *Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi*, - *Mongolian Studies*, edited by L.Ligeti, Budapest, 1970, p. 265-308.

²⁴ L.Ligeti, *Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi*, - *Mongolian Studies*, edited by Louis Ligeti, Budapest, 1970, p. 292; Л. Лигети, *Табгачский язык - диалект сянбийского*, - *Народы Азии и Африки*, 1969, N. 1, Москва, стр. 111.

²⁵ L.Ligeti, *Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi*, - *Mongolian Studies*, edited by Louis Ligeti, Budapest, 1970, p. 292.

²⁶ G. Schlegel ийм үзэгдэлийг англиар *Transmutation of Consonants* гэж нэрлэсэн байдаг.

байсаныгаа²⁷ дахин нэг сануулахыг хүсэж байна. Энэ нь солонгос, япон хэлний ханз нь өвөрмиц дуудалгатай ч тухайнхаа үеийн нангиад дуудалгад илүү ойрхон байх магадлалтай бөлгөө. Жишээлбэл: ханзаар тэмдэглэсэн табгач хэлний үгийн дотор (乞萬真) гэдэг үг буй бөгөөд үүнийг эртний хятад дуудалгаар нь *k'iet-miu' en-t'siën* гэж сэргээж болох боловч харь үг гэдэг талаас нь авч үзвэл наад зах нь эхиний хоёр үе нь өөрөөр буух ёстой болно. Энэ үгийг судласан Л. Лигети (L. Ligeti), К. Ширатори (K. Shiratori), П. Пеллио (P. Pelliot), П. А. Бүүдберг (P. A. Boodberg), В. Эберхард (W. Eberhard), Л. Базен (L. Bazin) нар цөм дээр өгүүлсэнчилэн, өртөөчилөн хөөж монгол хэлний “хэлмэрчин” гэдэг үг хэмээн сэргээсэн байдаг²⁸.

Хэрэвзээ энэ үгийн *k'iet-* хэмээх эхиний үеийг солонгосын “ханз” хэлний дуудалгаар сэргээвэл шууд *k'iel-* болох бөгөөд энэ нь монгол хэлний *kele* гэдэгт үлэмжихэн ойр болох нь харагдана. Харь үгийг тэмдэглэсэн эртний ханзын дуудалгыг тэнхрүүлэх ийм боломж байгааг анх солонгосч эрдэмтэн Б. Сумъяабаатар хөндсөн бөгөөд үүнийг солонгосын монголч эрдэмтэн, хэлшинжлэлч И Сөн-гю бүрэн боломжтой хэмээн хүлээн зөвшөөрч байна. Үүнээс үзэхүл наад зах нь солонгосын “ханз” хэлний дуудалгыг харгалзаж гэмээ нь хэд шатлаж өртөөлөн сэргээсэнээс илүү хялбар боловч аль алинаар нь тэнхрүүлээд харьцуулан шалгах боломжийг давхар олгох нь мэдээж юм.

Нэмэн тэмдэглэх нь: академич Л. Лигетийн табгач хэлний үгийн жагсаалтыг *нохой, мухар* хэмээх хоёр үгээр нэмсэн профессор А. Вовин (A. Vovin) 2007 онд *Табгач хэлний талаар дахин авч үзэх нь* гэдэг өгүүлэлдээ эртний ханзаар буй харь үгийн дуудалгыг сэргээхэд тухайн үеийн хятад хэлний хөгийг тооцох шаардалгатай хэмээн үзсэн бөгөөд жишээ нь: “хэлмэрчин” гэсэн утга бүхий, Л. Лигети профессорын *k'iet-miu' en-t'siën* гэж тэмдэглэсэн, дээр эш татсан (乞萬真) гэдэг үгийг *khji t mjonH tsyin* хэмээн галигласан байна²⁹. Энд *H* үсэгээр хятад хэлний ([chin. *qu-sheng*] the departing tone) хөгийг тэмдэглэсэн хэрэг бөгөөд ийнхүү өөрөөр галигласан нь дундад үеийн нангиад (Middle Chinese) хэлний дуудалгыг сэргээх Baxter³⁰-ын тогтолцоог баримтласантай холбоотой ажээ.

Бид сая сянбийн табгач хэлний хэрэглэгдэхүүнийг жишээ болгон авсан боловч судлагааны дээрхи хоёр арга нь ханзаар галиглан үлдээсэн монгол хэлний хөгжилийн үлэмж түрүү үеийн бүх дурасхалд нэгэн адил хамааралтай бөлгөө. Жишээлбэл: Хүн(нү) нарын удирдагчийг тэмдэглэсэн (单于) *шаньюй* гэдэг нэр томъёоны гарал, утгыг тэнхрүүлэх талаар Монголын Б. Сумъяабаатар, БНХАУ-ын Сайшаал, Хөх-өндөр, Жинган буюу Жангар³¹ зэрэг нэг бус эрдэмтэн анхаарсаар ирсэн байх бөгөөд монгол

²⁷ Ц. Шагдарсүрэн, *К вопросу о происхождении монгольского письма*, - Олон улсын монголч эрдэмтний III их хурал, III боть, Улаанбаатар, 1978, 286 - 290 х.

²⁸ L.Ligeti, *Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi*, -Mongolian Studies, edited by L.Ligeti, Budapest, 1970, p. 292.

²⁹ Alexander Vovin, *Once Again on the Tabgač Language*, - Mongolian Studies, Journal of The Mongolia Society, Volume XXIX, 2007, Indiana, Bloomington, [pp. 191-206], see pp. 194, 201: note 1.

³⁰ William H. Baxter, *An Etymological Dictionary of Common Chinese Characters*, Preliminary Draft of 28 October 2000. [See: Mongolian Studies, Journal of The Mongolia Society, Volume XXIX, 2007, Indiana, Bloomington, p. 205]

³¹ Б.Сумъяабаатар, *(Өвөг монгол хэлний чухаг дурсгалын) хэл, бичгийн судалгаа* -Д. Наваан, Б. Сумъяабаатар, *Өвөг монгол хэлний чухаг дурсгал*, Улаанбаатар, 1987, 31-155-р тал; Хөх-өндөр, *Шан-юй хэмээх үсэг авиаг шинжилэн тодорхойлох нь*, - “Монгол хэл утга зохиол” сэтгүүл,

хэлний “хан”³² гэдэг үгтэй холбон үзжээ. Энэ үгийн эхиний (单) үсэгийг сүүл үеийн хятад тольд “chan” хэмээн тэмдэглэдэг ч дээр үедээ “shan”, “dan”, “chan” гэдэг гурван зүйл дуудалгатай бөгөөд “shan-yu”-г түрүү үеийн тольд “*өргөн уудам тэнгэр мэт ажигуу*” хэмээн тайлбарласан байдаг ажээ. Иймд ханзаар тэмдэглэсэн Хүн(нү)-гийн үеийн энэ мэт олон монгол үгийн дуудалгыг сэргээх нь монгол хэлний хөгжилийн түрүү үеийн байдалыг тодруулах сонин бөгөөд судлах эзэнээ хүлээж байгаа бас нэгэн сэдэв даруй мөн. Үүнд ханзаар тэмдэглэсэн монгол гэж үзэх боломжтой олон үгийг судлах анхны зам чийрийг гаргаж өгсөн Фанг Чуанг-Яо (Fang Chuang-Yao), А. Бүүдберг (А. Woodberg), Л. Лигети (L. Ligeti), О. Прицак (O. Pritsak) зэрэг Ази болон Европ дахины олон эрдэмтэний холбогдох бүтээл онцгой байр эзлэнэ³³.

Хятан хэлний тухайд: Цаг хугацааны хувьд монгол бичигийн хэлний дараагийн шатанд хамаарах монгол хэлний баримт гэвэл даруй хятан бичигийн дурасхал болно. Хятан бичиг үсэг болон хятан хэлийг судласан профессор Чингэлтэй, Кара Жорж (Kara György) нарын судлагааны дүнгээс³⁴ үзэхүл хятан хэлний онцлог нь монгол бичигийн хэлнийхээс харьцангуй хол, Дундад үеийн монгол хэлний онцлогт илүү ойр болох нь тодорхой харагдана. Үүнд: *jau* (зуу < Мо. *jaγun*), *tau* (тав < Мо. *tabun*), *tau.la* (туулай < Мо. *taulai*), *s.au.ul.ga-* (суулга- < *saγulga-*) гэх мэтийн авиазүйн нэгэн тогтолцоог харж болох бөгөөд энэ нь Дундад үеийн монгол хэлний онцлогт хамаарч байна гэсэн үг.

Энэ ташрамд нэгэн зүйлийг нэмэн тэмдэглэхэд: хэдийгээр эрдэмтэд Дундад үеийн монгол хэлийг XI-XII зуунаас XV-XVI зуун гэж тоймлон үздэг боловч дээрхи баримт нь харьцангуй тодорхой болж буй X зууны хятан хэлнээ дундад үеийн монгол хэлний онцлог хэдийнээ буй болчихсоныг харуулж байгаа юм. Энэ нь хэлний хөгжилийн нэгэн үечилэл гэхэд харьцангуй богино хугацааг хамарсан Дундад үеийн монгол хэлний

Хөххота, 1990, N. 3 (109), 82-88-р тал; Жангар, *Хаан цолын үүсэл гарал*, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг (МУИС, Монгол судлалын сургууль), XV (153) боть, Улаанбаатар, 2000, 49-54-р тал; Сайшаал, *Монгол түүхийн зарим нэрсийг шинээр таних оролдолог* (1) – Сайшаалын өгүүлэлийн түүвэр, Хөххота, 2003 он, 147-152, 196-205.

³² Одоо бид *хан*, *хаан* гэдэг хоёр үгийн тухайд “*хаан*” нь “*хан*”-аасаа том гэж ухах болсон ч эрт болон дундад үеийн монгол хэлний дурасхалд, жишээ нь: дөрвөлжин бичигийн зарлигт Чингисийн тухайд дандаа “*хан*” гэсэн тодорхой баримт буй нь сонирхол татдаг бөгөөд энэ нь дээрхи саналыг батлаж байна. *Хан*, *хаан* гэдэг цолын ялгааны тухайд Б. Сумъяабаатар, И. дө Рахевильз (Igor de Rachewiltz) нар тусхайлан судласан нь буй [Б. Сумъяабаатар, *Өвөг монгол хэлний чухаг дурсгалын хэл, бичгийн судалгаа* -Д. Наваан, Б. Сумъяабаатар, Өвөг монгол хэлний чухаг дурсгал, Улаанбаатар, 1987, 31-155-р тал; Igor de Rachewiltz, *Qan, Qa'an and the Seal of Güyük*, - Documenta Barbarorum, Festschrift für Walther Heissig zum 70. Geburtstag, editors K. Sagaster, M. Weiers, Wiesbaden, 1983, pp. 272-281].

³³ Fang Chuang-Yao, *The Hsien Pei language* - Yenching Journal of Chinese Studies, Vol. VIII, 1930, pp. 1429- 1468 (хятадаад); Peter A. Woodberg, *The language of the T'o-pa Wei*, - Harvard Journal of Asiatic Studies, Vol. I, 1936, pp. 181, 184-185; L.Ligeti, *Mots de civilisation de Haute Asie en transcription chinoise*, - Acta Orientalia Hung., Tomus I, Budapest, 1950-1951, pp. 139-188; Louis Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, by L.Ligeti, Budapest, 1970, pp. 265-308; Omeljan Pritsak, *The Hsiung-nu word for “stone”*, - Tractata Altaica, -edited by D.Sinor, Wiesbaden, 1976, pp. 479-485.

³⁴ 清格爾泰 (編者) 吳英哲協助, *契丹小子釋爾問題*, 日本, 東京, 國立亞非語言文化研究所. 2002; Kara Gy. *On the khitan writing systems*, - MS, Tom. X, 1986/1987, Bloomington, pp. 19-24; Kara Gyorgy, *Books of the Mongolian Nomads, More than Eight Centuries of Writing Mongolian*, (First English Edition, Translated from the Russian by John R. Krueger), - Indiana University Uralic and Altaic Series, Denis Sinor, Editor, Volume 171, Indiana University, Bloomington, 2005, p.331 + Plates.


үргэлжлэцийг урагш нь эргэж харууштайг сануулж байгаа хэрэг бөгөөд энэ тухай үүнээс түрүүн нэг бус тэмдэглэсэн билээ³⁵.

Дээр өгүүлсэн бүх зүйлээс үзэхэд, Заваа Дамдин ламтаны “Хор чойнжунг” хэмээх түүхэнээ буй монгол бичигийн үүсэлтэй холбоо бүхий тодорхой мэдээ баримт нь хэлшинжлэлийн үүднээс, монгол бичигийн хэлний онцлогтой зөрчилдөх зүйл байхгүй байна гэж хэлэх үндэсийг бидэнд олгож байгаа юм.

³⁵ Ц. Шагдарсүрэн, *Эртний монгол хэлний хэрэглэгдэхүүнд хийсэн хоёр ажиглалт*, 1997 оны 8-р сард болсон Олон Улсын монголч эрдэмтний VII их хуралд тавьсан илтгэл; Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - *Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies)*, N. 6 (1998), Soeul, 1999, [pp. 61-139] 80-81-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм* (нэмэн зассан хоёдугаар хэвлэл), - *Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл, II дэвтэр)*, Улаанбаатар, 1999, [67-125-р тал] 81-82-р тал.

Заваа Дамдины “Хор чойнжунг” номоос авсан
эшлэл бүхий хэсэгээс





SUMMARY

The purpose of this article is to clarify the attempt for invention time of the Mongolian script on the materials in the “*Hor-chos-byun*” (“*History of Buddhism in Mongolia*”) by Sh.Damdin, Mongolian historian (named Zawaa), in comparison with feature of the Written Mongolian.

Based on the evidence of afore-named Tibetan source the following hypothetical supposition can be brought concerning the origin of the Mongolian Script: The Mongols did not adopt the Sogdian script through the Uighur in the 13th century, but the Mongols and the Uighur simultaneously adopted it from the Sogdian, much earlier, that is, approximately, in the 6th -7th centuries.